



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНХУЯГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Нэг. Халдварт бус өвчний хяналт, сэргийлэлт, эрт илрүүлгийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах							
1	Арга хэмжээ 1.1.1 ЗГҮАХ 2.1.5.4 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг УИХ-аар батлуулсан байна	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдана	Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх	УИХ-аар батлуулна	2024 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн УИХ-ын чуулганаар “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийг соёрхон баталсан. Хуулийн хэрэгжилт 2024 оны 04 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.	01-12 сар	100
2	Арга хэмжээ 1.1.6 ЗГҮАХ 2.1.5.5 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх стандарт, дүрэм, журам шинэчлэх	Шинээр батлагдсан стандарт, дүрэм, журам тоо	-	Шаардлагатай стандарт, дүрэм, журам батлуулсан байна	Эрүүл мэндийн сайдын 2024.02.07-ны өдрийн А/56 дугаар тушаалаар “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө”-г батлуулж. Төлөвлөгөөнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 1 стандарт, 3 дүрэм, 4 журмыг боловсруулж, батлуулахаар тусгасан. Үүнд: - НЭМТҮ-ний мэдээллийн сангийн ажиллах журам - НЭМ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам - НЭМТ-ийн дүрэм, бүтэц - НЭМТҮ-нд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журам - ЭМБ-ын НЭМ-ийн нэгж, албаны бүтэц, дүрэм боловсруулж батлуулахаар ажлын хэсэг гарч ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024.08.07-ны өдрийн “Засгийн газрын Үндэсний хороо, комисс, Үндэсний	01-12 сар	30




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 21 дүгээр тогтоолын 18 дугаар хавсралтаар “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүн Ерөнхий сайдаар ахлуулан 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан.		
3	Арга хэмжээ 1.1.2 ЗГҮАХ 2.1.5.7 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах	10 аймаг, 3 дүүрэгт НЭМТ байгуулна	-	Дүрэм, журмыг боловсруулж, батлуулна	НЭМТ байгуулаагүй.	01-12 сар	0
4	Арга хэмжээ 1.1.3 ЗГҮАХ 2.1.1.4 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.5 “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2023 оны арга хэмжээний хэрэгжилт 80 хувьд хүрсэн	Арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтыг 70 хувьд тус тус хүргэсэн байна	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд арга хэмжээний хэрэгжилт 73.8% -тай байна. Үүнд: ➤ 1-р Зорилт 86.7 %, ➤ 2-р Зорилт 81.2 %, ➤ 3-р Зорилт 50.5 %, ➤ 4-р Зорилт 74.6 %, ➤ 5-р Зорилт 56% ➤ 6-р Зорилт 6% Улсын хэмжээнд 2024 оны 11 сарын байдлаар Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 304542 (33.4%) хүн хамрагдсанаас 64 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна. Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан эрт илрүүлэгт зорилтот насны нийт 77064 (35.1%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 3.7 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй. Үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 29 тохиолдол бүртгэгдсэн байна.	01-12 сар	39




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Хөхний хорт хавдрын боломжит илрүүлэгт 483717 эмэгтэй хамрагдсанаас 1315 (0.3%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.		
5	Арга хэмжээ 1.1.4 ЗГҮАХ 2.1.1.6 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.6 "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2023 оны арга хэмжээний хэрэгжилт 45 хувьд хүрсэн	Харшлын шалтгаант өвчлөлийн түвшин 30 хувиар бууруулна	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 64.5 хувьтай байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➢ 1-р Зорилт 66.1 %, ➢ 2-р Зорилт 80.7 %, ➢ 3-р Зорилт 59.0 %, ➢ 4-р Зорилт 38.5 %, 	01-12 сар	70
6	Арга хэмжээ 1.1.5 МУХТЖҮТ 2.2.2 Арга хэмжээ 1.4. ЭМССТ 1.9 Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо зохион байгуулах	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн амын хувь	2023 онд эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдсан хүн амын хувь 38,9	Эрт илрүүлэг үзлэгт хүн амын 50 хувийг хамруулсан.	2022 оны 05 сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 сарын 13-ны өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1 569 815 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 46.4 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/150 дугаар тушаалаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх чиглэлээр 1.3 тэрбум төгрөгийн төсвийг баталж 868.65 сая төгрөгийн санхүүжилтийг УНТЭ, УХТЭ, УГТЭ-д олгосон. 2022 оноос хойш эрт илрүүлэг үзлэгт 87,9 тэрбум төгрөгийн зардлыг ЭМДЕГ-аас гаргасан байна. Эрүүл мэндийн сайд, Боловсрол сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалын дагуу хийгдэж буй 6 настны эрт илрүүлэгт нийслэлийн хэмжээнд 27,070 хүүхэд хамрагдсан.	01-12 сар	68
7	Арга хэмжээ 1.1.7 ДЭМБ-ын санаачилгын ХБӨ/ЗСӨ-өөс хянах нэн тусламж, багцыг МонПЕН хүрээнд сэргийлэх, шаардлагатай үйлчилгээний нэвтрүүлж	Багцыг хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо	Төсөл 14 аймаг, 3 дүүрэгт хэрэгжсэн	Төслийг 7 аймаг, нийслэлийн 2 дүүрэгт хэрэгжүүлсэн байна.	МонПЭН-ийг 7 аймаг, 6 дүүрэгт нэвтрүүлж, одоогийн үүссэн асуудлыг шийдвэрлэх Техникийн ажлын хэсгийг ЭМС-ийн 2024.10.21-ний өдрийн А/414 дүгээр тушаалаар батлуулав. МонПЭН санаачилгыг шинээр нэвтрүүлэхтэй холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Суурь үнэлгээг хийсэн.	01-12 сар	70



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хэрэгжүүлэх төслийг өргөжүүлэх				<p>2. Насанд хүрэгсдийн артерийн гипертензийн удирдамжийг боловсруулсан.</p> <p>3. ЭМАШТУ-ний түвшинд зүрх судасны өвчний менежментийн арга зүйн багцыг хэрэгжүүлэх зааврыг боловсруулсан.</p> <p>4. Улаанбаатар хотын 200 гаруй АШЭМБ-д МонПЭН санаачилгын багцыг нэвтрүүлэх эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтын удирдамж, төсөв, сургагч багшийн сургалтын хөтөлбөрийг 2024 оны 11 дүгээр сард батлуулсан. Сургагч багшийн сургалтад хам талаар 2024.12.02-ны өдрийн 2/5034 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.</p> <p>5. МонПЭН санаачилгыг өргөжүүлэх тухай албан бичгийг 2024.11.14-нд ДЭМБ-д хүргүүлж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэрээг ЭМС-аар 2024.12.02-нд батлуулсан.</p> <p>6. Ажлын хэсгийн цахим болон биечилсэн уулзалт 5, НЭМҮТ, Нийслэлийн ЭМГ, АШЭМБ-ын төлөөлөлтэй өргөтгөсөн уулзалтыг тус тус хийсэн.</p>		
Хоёр. "Сэтгэцийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг хянах"							
8	Арга хэмжээ 1.2.1. "Сэтгэцийн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/-г шинэчлэн боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	1,2 дугаар үндэсний хөтөлбөр	Төлөвлөгөө батлагдсан байна	<p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/148 дугаар тушаалаар "Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээний 2024-2027 оны төлөвлөгөө"-г баталсан. Төлөвлөгөөнд 4 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2024 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар хэрэгжилт 53%-тай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 1-р Зорилт 2% ➢ 2-р Зорилт 60% ➢ 3-р Зорилт 75% ➢ 4-р Зорилт 75% <p>(Эрүүл мэндийн сайдын тушаалыг https://moh.gov.mn цахим хаягт байршуулсан)</p>	01-12 сар	100
9	Арга хэмжээ 1.2.2.	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт	Тамхины хяналтын	УИХ-аар хэлэлцүүлж,	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бүрдлийг ханган,	01-12 сар	90



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	өөрчлөлт орж, батлагдсан байна	тухай хууль 2005 он Тамхины хяналтын суурь конвенци, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протокол	батлуулсан байна	хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2024.04.12-ны өдрийн 1а/1499 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2024.04.24-нд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх байсан боловч тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. (ЭМЯ чиг үүргийнхээ дагуу хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу өргөн барьсан) УИХ-ын даргын 110 дугаар захирамжаар "Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлан, санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг"-т мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох албан тушаалтны нэрийг 2024.11.12-ны өдрийн 1а/4616 дугаар албан бичгээр УИХ-ын гишүүн О.Номинчимэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг 2024.11.27-ний өдөр хуралдсан.		
10	Арга хэмжээ 1.2.3. Ерөнхийлөгчийн зарлиг Дугаар 2022_43 1.7. Хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах агуулгыг тусгах;	Сайдын албан тоотыг илгээсэн байна	Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2023 он	Сурталчлан таниулах агуулга, саналыг хүргүүлнэ	ЕБС-ийн сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтнууд, нийт 80 оролцогч нарт 2024.05.14-ны өдөр сургалт зохион байгуулсан. Хүүхэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн 12 цуврал подкастыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс бэлтгэж, FM107.5, Монголын радиогоор 25 удаагийн цацалт хийж, ЕБС-ийн удирдлагуудад тогтмол түгээх байдлаар хувилж өгсөн. Архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах сургалтыг ЕБС-г түшиглэн явуулахаар Нийслэлийн боловсролын газартай гэрээ байгуулсан. 2024.12.12-ны өдөр 23 дугаар сургууль дээр сургалт, нөлөөллийн ажлыг явуулна.	01-07 сар	70
11	Арга хэмжээ 1.2.4.	Арга хэмжээ	Засгийн газрын 224	Тамхины хяналтын	Хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх хөтөлбөрийг эрчимжүүлэхээр "Худлаа ярихаа	01-12 сар	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	<p>Монгол Улсын Их хурлын байнгын хорооны 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаар тогтоол: Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</p>		<p>дүгээр тогтоол</p>	<p>тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.</p>	<p>зогсоо" аяныг "Тамхины үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалцгаая!" уриатайгаар зохион байгуулахаар 2024.05.13-ны өдөр Эрүүл мэндийн дэд сайдаар удирдамж батлуулсан. Удирдамжид дараах зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаа явуулсан. Үүнд:</p> <p><u>1 дэх зорилтын хүрээнд:</u></p> <p>2024.05.31-ний "Дэлхийн тамхигүй өдөр"-ийг ҮЦХ-д, 06.01-ний "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр СБ-ын талбайд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>МОНҮТ-ийн 2024.05.30 болон 11.22-ны өдөр "Нээлтэй хором" хэлэлцүүлэг нэвтрүүлэгт олон нийтэд чиглэсэн танин мэдэхүйн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p> <p><u>2 дахь зорилтын хүрээнд:</u></p> <p>Хүүхдийн зусланг түшиглэн явуулж, Шонхор, Сансар, Найрамдал зусланд амарч буй өсвөр насны 750 хүүхдэд сургалт, явуулж, зөвлөмж, хүргэсэн. Дотоодын цэргийн 05 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж буй 18-19 насны 300 цэрэгт сургалт явуулсан.</p> <p>2024.12.03-ны өдөр ЦЕГ-ын 05 дугаар ангид "Ажлын байрны сэтгэцийн эрүүл мэнд, дондолт" сэдвээр 150 албан хаагчдад мэдээлэл хүргэсэн.</p> <p><u>3 дахь зорилтын хүрээнд:</u></p> <p>2024.12.05-ны өдөр УБ хотын Захирагчийн ажлын албатай хамтран төвийн 6 дүүргийн архи, тамхи худалдаалдаг бар цэнгээний газар, зах худалдааны төв, зоогийн газар, ресторан зэрэг 120 байгууллагын удирдлагуудтай уулзаж, Тамхины хяналтын тухай хууль, Архидан согтууруулахтай тэмцэх тухай хууль, түүнд тавих хяналт, эрүүл мэндэд учруулж буй хор</p>		




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					хөнөөлийг танилцуулсан сургалтыг явуулж, тэдний саналыг сонсож, зөвлөмж хүргэсэн. (Удирдамжийг хавсаргав)		
12	Арга хэмжээ 1.2.5. ЗГҮАХ 2.1.5.6 ЭМССТ 1.14 Тамхины хяналтын суурь конвенц 2030 төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилтийн тайлан	Тамхины хяналтын суурь конвенц 2030 төслийг 2023 онд хэрэгжүүлсэн тайлан	Төслийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөх “Тамхины хяналтын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бүрдлийг ханган, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2024.04.12-ны өдрийн 1а/1499 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тамхины хяналтын суурь конвенцын 5.3-д тусгагдсан “Оролцогч Талууд тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг боловсруулах болон хэрэгжүүлэх явцад эдгээр бодлогуудыг тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт эрх ашгаас үндэсний хууль тогтоомжийн дагуу хамгаална” заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. FCTC-2030 төслийн 2024-онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж боловсруулав. (Хуудас-4) Үе тэнгийн сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг Ерөнхий боловсролын Гётө сургуулийн ахлах болон дунд ангийн нийт 25 суралцагчдад “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор уршиг”, “Дэлгэцийн донтолт” сэдвээр 2024.02.07-ны өдөр сургалт зохион байгуулж үе тэнгийн сургагч багш, клубын идэвхтэн хүүхдүүдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн. Тус сургалтаар “Танд асуулт байна уу?” гарын авлага 30 ширхэг тараасан. Видео шторк-1 “Тамхи татах нь уушгины архаг бөглөрөлт өвчний гол шалтгаан” сэдвээр шторк түгээж 22000 үзэгчдэд хүргэсэн Инфографик- 28 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим хуудсаар 28 удаа мэдээлэл сурталчилгааны материалыг байршуулан иргэд олон нийтэд	01-12 сар	100

4




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					сурталчлан ажилласан. (Хандалт 31504, хуваалцсан 181) ДЭМБ-аас боловсруулсан электрон тамхи, шинэ төрлийн тамхины бүтээгдэхүүний хор хөнөөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарласан 3 төрлийн видео шток, 6 төрлийн зурагт хуудсыг орчуулж дуу оруулах, орчуулгыг унших боломжтойгоор өгүүлбэрт оруулж жендэрийн мэдрэмжтэй сургалт, сурталчилгааг хүргэсэн.		
13	Арга хэмжээ 1.2.6. Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг 1.12 Монгол улсын амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлохыг завдсан тохиолдлуудад урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийх	Зохион байгуулсан аян, мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо	ЭМС-ын 2023 оны А/137 дугаар тушаалд тусгагдсан шалгуур үзүүлэлт 3.4.2	Календарчилсан төлөвлөгөө батлуулж, бэлтгэл ажлыг хангана	Монгол Улсад амиа хорлох үзэгдлийн тархалтын судалгааны тойм би амиа хорлолтын шалтгаан сэдэл, урьдчилан сэргийлэлтийн асуудал” хэлэлцүүлэг 2024.03.28-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн байранд зохион байгуулагдаж, салбар бүр мэдээллээ нэгтгэх, хамтран ажиллах, хариу арга хэмжээг авахыг даалгасан. Хүн амыг амиа хорлохоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, амиа хорлох төрх үйлд өртөх эрсдэл, эрсдэлийн түвшнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөний төслийг ДЭМБ-ын LIVE LIFE нотолгоонд суурилсан интервенцтэй уялдуулан боловсруулж, салбар бүрийн саналыг тусгахаар 2024.11.15-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Уулзалтад ХЗДХЯ, БХЯ, БЯ, ГБХНХЯ, НЗДТГ, Хордлогын яаралтай тусламжийн төв, СЭМҮТ, НЭМҮТ, ГССҮТ-ийн төлөөлөл нийт 19 хүн оролцсон. Жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны өдрийг “Амиа хорлохын эсрэг” өдрөөр 60 сэтгүүлчдэд сургалт явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дээрх үйлдлийг нийтлэхдээ хүний эрхийг хүндэтгэх, бусдад сэдэл өгөхгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөмж болгосон.	01-07 сар	100
Гурав. “Нөхөн үржихүй, эрэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах”							
14	Арга хэмжээ 1.3.1. “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/399	Эрүүл мэндийн сайдын тушаал	“Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын А/107	01-12 сар	70


2



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	тухай” журмыг шинэчлэн батлуулах		дүгээр тушаал	батлагдсан байна	дугаар тушаалаар 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, ажлын хэсгийн хурлыг 5 удаа хийсэн. ЭХЭМҮТ, АШУҮИС, Нийслэлийн ЭМГ, 6 дүүргийн ЭМТ-ийн НЭМОД, Өрхийн менежер, ХЕЗ, өсвөр үеийн эмч, ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүд, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, Азийн хөгжлийн банк, ТББ-уудын төлөөлөл болох нийт 41 хүний бүрэлдэхүүнтэй уулзалт, хэлэлцүүлгийг 2024.05.10-ны өдөр зохион байгуулж журмын төсөлд санал авсан. Журмын төслийг нэгтгэн ажлын хэсгээр 2024.09.20-ны өдөр хэлэлцүүлэн, эцэслэн боловсруулж газрын дарга нараас санал авч нэгтгэн, Эрүүл мэндийн сайдад хянагдаж байна.		
15	Арга хэмжээ 1.3.2. Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай” журмыг шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 11 сарын 27 - ны А/480, А/739 тоот тушаал	Эрүүл мэнд, Боловсролын сайдын хамтарсан тушаал батлагдсан байна	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай” А/480, А/739 дүгээр тушаалыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/44 дүгээр тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа хуралдуулан хамтарсан тушаалын төслийг боловсруулан газрын дарга нараас санал авч нэгтгэн, Эрүүл мэндийн сайдад хянагдаж байна. Боловсролын яамны газрын дарга нараар хянагдан, Боловсролын сайд 2024.10.15-ны өдөр тушаалын төсөл дээр зурсан. Төр болон хувийн хэвшлийн 23 их, дээд сургуулийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх боломжгүй 998 оюутан, суралцагчдын судалгааг БЯ-тай хамтран гаргаж ЭМДЕГ-т 2024.03.11-ний өдрийн 6/1005 дугаар албан бичгээр хүргүүлж, суралцагч бүрээр он, оноор тооцоолол гаргуулсан. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөд нийт 45 сая төгрөг шаардлагатай байгааг тооцоолон Эрүүл мэндийн сайдын 2024.03.21-ний өдрийн “Төсөв баталж, санхүүжилт олгох тухай” А/128 дугаар тушаалыг батлуулж, холбогдох санхүүжилтийг	01-12 сар	70




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Эрүүл мэндийн сайдын багцаас гаргахаар шийдвэрлэсэн. БЯ-нд 2024.04.02-ны өдөр 2/2304 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн сайдын А/128 дугаар тушаалыг хүргүүлсэн.		
16	Арга хэмжээ 1.3.3. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журмыг шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/563 дугаар тушаал	Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдсан байна, хэрэгжилт 60%-д хүрсэн байна	Эрүүл мэндийн сайдын А/445 дугаар тушаалаар "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийг байгуулан нийт 9 удаа хуралдуулсан. Журмын төсөлд санал авах хэлэлцүүлэг, уулзалтыг ЭХЭМҮТ, ЭМХТ, Нийслэлийн ЭМГ, 9 дүүргийн ЭМТ-ийн НЭМОД, Өрхийн менежер, НҮЕЗ эмч нар болон ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүд, Мари Стопс эмнэлгийн удирдах албан тушаалтан болох 60 хүний төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн мэдээллийн сан үүсгэж, тасралтгүй хяналт үнэлгээ хийж тусламж үйлчилгээг тогтворжуулах нь чухал байсан учир дээрх тушаалыг шинэчлэн, боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2024.01.09-ний өдөр "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах журам шинэчлэн батлах тухай" А/11 дүгээр тушаал батлагдсан. Уг тушаалыг 2024.01.12-ны өдрийн 6/158 дугаар албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын А/11 дүгээр тушаал, шийдвэр танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт оролцох тухай 5/2719 тоот албан бичгийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн 2024.06.20-ны өдөр ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭНЭҮТ-II, НЭМГ, Амаржих газар, дүүргийн ЭМТ, Өрхийн ЭМТ-үүдийн удирдлага болон холбогдох эмч, мэргэжилтэн нар болох нийт 50 хүн оролцсон уулзалт, хэлэлцүүлгийг 2024.06.26-ны өдөр зохион байгуулсан. Мөн 21 аймгийн удирдах болон холбогдох албан хаагчдыг оролцуулсан цахим уулзалт хэлэлцүүлэг зохион	01-12 сар	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					байгуулах тухай 6/3724 тоот албан бичгийг 2024.09.12-ны өдөр аймгийн ЭМГ-ын дарга нарт явуулан нийт 100 хүн оролцсон цахим уулзалтыг 2024.09.17-ны өдөр зохион байгуулсан. Тушаалын хэрэгжилтийн үр дүн: Одоогийн байдлаар ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албаны жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тандалт мэдээллийн нэгдсэн сан бүхий цахим программд төр болон хувийн хэвшлийн 740 эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл орж, 35,335 хувь хүний талаарх мэдээлэл бүртгэгдсэн байна.		
17	Арга хэмжээ 1.3.4 ЗГҮАХ 2.1.1.3 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.8 "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт 50 хувь	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 80,1 хувьтай байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➢ 1-р Зорилт 69% ➢ 2-р Зорилт 89% ➢ 3-р Зорилт 81,5% ➢ 4-р Зорилт 94% ➢ 5-р Зорилт 67,1% байна. Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт: Улсын хэмжээнд 2024 оны 12 сарын 03-ны байдлаар 52514 эх төрж, 52830 хүүхэд амьд төрсөн байна. Амьгүй төрөлтийн түвшин 5.1 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан байна. Улсын хэмжээнд 11 эх эндэж, эхийн эндэгдлийн харьцаа өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна. Харин тав хүртэлх насны 809 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 15.3 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн бол нэг хүртэлх насны 645 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 12.2 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна. Нярайн эндэгдэл 403 нярай эндэж, эндэгдлийн түвшин 7.6 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.	01-12 сар	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					<i>Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.</i>		
18	Арга хэмжээ 1.3.5 ЗГҮАХ 2.1.1.7 Арга хэмжээ 3.5. МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.7 “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлэх.	ЗГҮАХ-ийн хүрэх түвшин	Арга хэмжээний хэрэгжилт 50,6 хувьд	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдах эрэгтэйчүүдийн хувь 70-д хүрсэн байна.	<p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 75,6 хувьтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 1-р Зорилт 65.8% ➤ 2-р Зорилт 89% ➤ 3-р Зорилт 84.8% ➤ 4-р Зорилт 62.6% байна. <p>Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн шалгуур үзүүлэлт: 2022.05.01-ний өдрөөс 2024.11.14-ний өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1,549,479 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 45.8 хувийг эзэлж байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 676,324 буюу 43.6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь зорилтот түвшний 62.8 хувийг эзэлж байна. 2024 оны байдлаар улсын хэмжээнд төрийн 23 эрүүл мэндийн байгууллагад урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаагаас нийслэлд 12, аймаг 11 байна.</p> <p>2023-2024 оны хичээлийн жилд Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал судлал төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр 8 эмч суралцахаас 8 суралцаж, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Хэнтий зэрэг 7 аймагас 7 их эмч Төрийн сангийн зардлаар, үлдсэн 1 нь хувийн зардлаар суралцаж байна.</p> <p><i>Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.</i></p>	01-12 сар	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
19	Арга хэмжээ 1.3.6. Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяныг зохион байгуулах	Батлагдсан удирдамж, хөтөлбөр	2023 онд 3 сарын үйл ажиллагаа зохион байгуулсан	Үйл ажиллагаа 80% хийгдсэн байна	<p>Оюутан, суралцагчдын эрүүл мэндийг дэмжих сарын аян зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, аяны хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөөг 2024.09.25-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ЭМДЕГ, НЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ болон дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд үйл ажиллагааг зохион байгуулах тухай 2024.09.27-ны өдрийн 6/3951 тоот албан бичиг хүргүүлсэн.</p> <p>Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг 2024.10.01-ний өдөр НЭМБГ-ын даргаар батлуулан, хуваарийн дагуу эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн ажил, оюутан, суралцагчдыг эрт илрүүлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 28-ны хооронд 36.684 оюутан, 50.380 удаагийн гүйлгээгээр 561.982.859 сая төгрөгийн шимтгэл төлсөн байна. Нийт 83 контент бэлтгэснээс инфографик 56, цаг үе үйл явдлын мэдээ мэдээлэл 10, хөдөлгөөнт постер 10, рийл 7-ыг бэлтгэн түгээсэн нь 275.032 хүнд хүрч 2.481 удаа хуваалцсан байна. МУБИС, МУИС, ШУТИС, Дотоод хэргийн их сургуулийн оюутан, залуусын дунд "Нөхөн үржихүй- Гэр бүл төлөвлөлт", "БЗДХ-өөс Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ", "Архи, тамхины хор уршиг", "Эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдол" сэдвүүдээр эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 4139 оюутан залуус хамрагдсан. 31 их дээд сургуулийн нийт 3350 оюутан, залуучууд эрт илрүүлэгт хамрагдаж, 316 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь Эрүүл мэндийн сайдын багцаас төлсөн 998 оюутан, суралцагчдаас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэгт одоогийн байдлаар 307 оюутан хамрагдсан байна. 	09-12 сар	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
20	Арга хэмжээ 1.3.7. Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагч, цэрэг, сонсогчдыг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Батлагдсан төлөвлөгөө	Батлан хамгаалахын дэд сайд, Эрүүл мэндийн дэд сайдын хамтарсан ажлын удирдамж	Төлөвлөгөөний хэрэгжилт 50%-д хүрсэн байна.	<p>Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх 9 зорилт, 43 үйл ажиллагаа бүхий цаглавар үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Эрүүл мэндийн дэд сайдаар батлуулсан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Нүүдлийн эмнэлгийг орон нутагт ажиллуулан эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх тухай” А/150 дугаар тушаалын дагуу Цэргийн төв эмнэлэг эрт илрүүлэг, үзлэгийг цэрэг, армийн албан хаагч, цэрэг, сонсогчдод болон эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулах хуваарь гарсан.</p> <p>Цэргийн төв эмнэлэг нь суурин болон хөдөлгөөнт амбулатори гэсэн 2 байдлаар эрт илрүүлэгт оролцсон. Үүнд:</p> <p>➢ Суурин үзлэгийг Цэргийн төв эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д Улаанбаатар хот болон хотын ойролцоох Зэвсэгт Хүчний анги салбарт алба хааж буй бүрэлдэхүүн, Баянзүрх дүүрэгт байрлах Дотоод хэргийн их сургуулийн оюутан, суралцагчдад эрт илрүүлэг үзлэг хийн нийт 6244 иргэнийг хамруулсан.</p> <p>Хөдөлгөөнт амбулаторийн үзлэгийг хөдөө орон нутагт байрлах Зэвсэгт Хүчний анги салбарт алба хааж буй бүрэлдэхүүн тэдгээрийн ар гэрийн гишүүд, тэтгэвэрт чөлөөнд байгаа бүрэлдэхүүн болон тухайн анги салбар байрлаж байгаа сум орон нутгийн иргэдэд үзлэг шинжилгээг хийж 2024 онд нийт 7554 км замыг туулж, 4404 иргэнийг үзлэг оношилгоонд хамруулсан.</p>	01-12 сар	100
Дөрөв. Осол, гэмтэл, хүчирхийлэл, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хэрэгжилтийг зохицуулах							
21	Арга хэмжээ 1.4.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар	Төлөвлөгөөний хэрэгжилт	Төлөвлөгөөний хэрэгжилт 70%	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, салбар дундын 2024 оны төлөвлөгөөг ЖҮХ-ноос баталж ирүүлсэн, тус төлөвлөгөөнд ЭМС хариуцан хэрэгжүүлэх 5 үйл ажиллагаа орсон. Шинээр батлуулсан бодлогын баримт бичиг:	01-12 сар	100



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	дундын стратеги бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх				<p><u>Салбар хоорондын хамтарсан тушаал:</u></p> <p>1. ГБХНХЯ, ХЗДХЯ, БЯ, ЭМЯ, ЦХЯ-ний хамтарсан “Хүүхдийн эрх хамгааллын арга хэмжээний 2024-2025 оны төлөвлөгөө”;</p> <p><u>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд:</u></p> <p>1. ЭМС-ын 2024 оны А/111 дугаар тушаалаар “Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027 он”;</p> <p>2. ЭМС-ын 2024 оны А/147 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын 2024-2027 оны арга хэмжээний төлөвлөгөө”;</p> <p>3. ЭМС-ын 2024 оны А/148 дугаар тушаалаар “Сэтгэцийн эрүүл мэнд” цогц арга хэмжээний 2024-2027 оны арга хэмжээний төлөвлөгөө”;</p> <p>4. ЭМС-ын 2024 оны А/244 дүгээр тушаалаар “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлуулсан.</p> <p>(ЖҮХ-ны 01 дүгээр тогтоолоор батлагдсан салбар дундын 2024 оны төлөвлөгөө, биелэлтийг хавсаргав)</p>		
22	Арга хэмжээ 1.4.2. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сэргийлэх эрүүл мэндийн салбарын төлөвлөгөө батлуулах, хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөө	Төлөвлөгөөний төслийн боловсруулалт 50 хувь	Төлөвлөгөөг батлагдана, хэрэгжилтийг 40 хувьд хүргэнэ	<p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/111 дүгээр тушаалаар “Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээний 2024-2027 оны төлөвлөгөө”-г батлуулж, 4 зорилт 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2024 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар хэрэгжилт 41%-тай байна.</p> <ul style="list-style-type: none"> ➢ Зорилт-1 75% ➢ Зорилт-2 44,3% ➢ Зорилт-3 25% ➢ Зорилт-4 20% <p>Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:</p>	01-12 сар	100



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					<p>✓ ЭМС-ын А/611 дүгээр тушаалыг шинэчлэх төсөлд хүчирхийллийн хохирогч болсон тохиолдол бүрд олон улсын Т26 оношийг тавьж бүртгэх, ингэснээр осол гэмтэл, хүчирхийллийн шалтгаант өвчлөл, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгдсэн статистик мэдээлэлтэй болохыг тодорхойлж, санал хүргүүлсэн.</p> <p>✓ ЭМС-ын 318 дугаар тушаал шинэчлэгдэж байгаатай холбогдуулан тушаалын хавсралтаар батлагдах асуумжид “Жирэмсэн эмэгтэйд хүчирхийллийг илрүүлэх асуумж” болон ГБХ-тэй тэмцэх хуульд заасан хүчирхийллийн 4 хэлбэрээр “Эмэгтэй өөрөө өөрийгөө илрүүлэх” шалгуур асуумжийг нэмэлтээр тусгуулахаар ЭТБГ-д саналыг хүргүүлсэн</p> <p>✓ Нийгмийн эрүүл мэндэд хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судалж, зөвлөмж гаргасан. ёс зүйн хяналтын хороонд материалаа өгсөн байна.</p> <p><i>(төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсаргае)</i></p>		
23	Арга хэмжээ 1.4.3. Эрүүл идэвхтэй амьдрах тэгш боломж бүрдүүлж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах ажлыг зохион байгуулах	Хамрагдсан байгууллага, хүний тоо, тайлан	-	2 сургалт зохион байгуулна	<p>МУ-н Ерөнхий сайдын 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 71 дүгээр захирамжаар “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)” батлагдсан. Салбар дундын төлөвлөгөөнд тусгагдсан 6 ажил үйлчилгээг Эрүүл мэндийн салбар хариуцан хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <p>1. Суурин үзлэгийг Цэргийн төв эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д Улаанбаатар хот болон хотын ойролцоох Зэвсэгт Хүчний анги салбарт алба хааж буй бүрэлдэхүүн, Баянзүрх дүүргийн зарим хорооны иргэдэд эрт илрүүлэг үзлэг хийн нийт 6244 иргэнийг хамруулсан байна.</p> <p>2. Эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Энхийг сахиулагчдын эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний удирдамж”-ийг Дэд сайдаар батлуулж</p>	01-12 сар	100



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					<p>БХЯ-ны ЗХЖШ-ийн алба хаагчид болон харьяа анги бэлтгэлийн цэргийн албан хаагчдад 7 хоног бүрийн Баасан гарагт сургалтыг тогтмол явуулж, тэднийг хорт зуршлаас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах зан үйлийн нөлөөллийн арга хэмжээг хуваарийн дагуу СЭМҮТ, НЭМҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ тус тус зохион байгуулж ажилласан.</p> <p>3. Дотоодын цэргийн 05 дугаар ангийн хугацаат хэргийн алба хааж буй 250 цэрэг, байнгын цэргийн албаны 50, офицер, албан хаагч 100 эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 2024.12.03-ны өдөр явуулсан. Сургалтыг ЭХЭМҮТ, СЭМҮТ явуулсан.</p>		
24	Арга хэмжээ 1.4.4. Осол гэмтлээс сэргийлэх, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Анхны тусламжийн 1 сургалт	1 сургалт зохион байгуулна	<p>"Осол гэмтлээс сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх ажлын удирдамж"-ийг 2024.05.10-ны өдөр Эрүүл мэндийн Дэд сайдаар батлуулсан. Удирдамжийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>"Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе" аяны хүрээнд хүүхдийн Шонхор, Сансар зуслан, Найрамдал төвд амарч буй 14-18 насны 650 хүүхдүүдэд осол гэмтэл хүчирхийллээс сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг 2024 оны 07-08 сард явуулсан.</p> <p>2024.05.22-ны өдөр зохион байгуулагдсан "Марафон гүйлт", 5 сарын 31-ний "Дэлхийн тамхигүй өдөр"-ийг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд, 06 дугаар сарын 01-ны өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр, Сүхбаатарын талбайнд тус тус арга хэмжээ зохион байгуулсан. Энэ үеэр осол гэмтлээс сэргийлэх мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг явуулж, осол гэмтлээс сэргийлэх 4 төрлийн зөвлөмж бүхий брошур, зурагт хуудас бүхий 655 ширхэг тараах материалыг иргэдэд тараасан.</p> <p>Жил бүр "Автомашингүй өдөр"-ийг 2024.09.21-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус өдрөөр ГССҮТ, НҮЭНТ, СЭМҮТ, нийслэлийн 3 дүүргийн ЭМТ-д осол гэмтлээс сэргийлэх, осол гэмтлээс шалтгаалсан сэтгэцийн эрүүл мэндэд учрах эрсдэл, даван туулах сэтгэл зүйн зөвлөгөөг өгч, АХА тэмцээн зохион</p>	01-12 сар	100



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					байгуулж, эхний 4 оролцогчдод гарын бэлэг гардуулж, тайзны жүжигчилсэн тоглолт үзүүлсэн. Австрали улсын EMS Global олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд 2024.09.30-нд Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 5 салбарын 45 эмч, 45 жолооч, ЗХЖШ-ын цэргийн ангийн 12 эмч, нийт 102 эмчид яаралтай тусламжийг газар дээр нь болон эмнэлэг хүрэх хүртэлх тусламж, аюулгүй тээвэрлэлт, хэрхэн багаар ажиллах онол, дадлага хосолсон 5 хоногийн сургалтыг явуулсан. Сургалтыг АНУ, Канад, Англи, Австрали улсын яаралтай тусламжийн мэргэжилтнүүд багшилсан. "Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе" аяны хүрээнд 2025-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ТНБД-аар батлуулж 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2/5040 албан бичгээр АНЭМГ, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.		
25	Арга хэмжээ 1.4.5. Гамшиг, онцгой байдлын үеийн Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх салбарын болон салбар хооронд мэдээлэл солилцох чадавхыг сайжруулах	Үнэлгээний тайлан, зөвлөмж	-	Үнэлгээ хийгдэнэ	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар, НҮБ-ХАС-тай хамтран "Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний бэлэн байдлын үнэлгээ хийх" арга аргачлалыг боловсруулж, арга аргачлалаа ОБЕГ-аар батлуулсан. Үнэлгээний дүн: Үндэсний болон орон нутгийн үнэлгээний 76 асуулгад хариулсан байдалд хийсэн дүн шинжилгээгээр 40 үзүүлэлт (53%) нь "Бүрэн хангасан" гэж үнэлэгдсэн нь гамшиг, онцгой байдлын үеийн БНҮЭМ-ийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх одоо байгаа хүчин чадал, чадавхыг тодорхойлж байна. Арван таван үзүүлэлтийг (20%) нь "дутуу хангасан" гэж үзсэн бөгөөд энэ нь цаашид сайжруулах шаардлагатай хэсгүүдийг онцолж байна. Хамгийн ноцтой нь 21 үзүүлэлт (27%) нь "Хангалтгүй" гэж үнэлэгдэж байгаа нь гамшиг, онцгой байдлын үед БНҮЭМ-ийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх	01-12 сар	100

2



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					<p>бэлэн байдлыг хангахад шийдвэрлэх ёстой орхигдсон асуудлыг онцлон тэмдэглэжээ. Ерөнхийдөө, эмнэлгийн мэргэшсэн ажилтан, байгууллагын хувьд гамшиг, онцгой байдлын үед үзүүлэх БНҮЭМ-ийн нэн шаардлагатай багцад тусгагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэхэд үндэсний хэмжээнд байгаа эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг «Хамгийн наад захын шаардлагыг хангана» гэж үнэлж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг “Хангалтгүй” гэж үнэлсэн байна.</p> <p>Зөвлөмж: Эрүүл мэндийн салбарын яаралтай тусламжийн нөөцийн жагсаалтад гамшиг онцгой байдлын үеийн БНҮЭМ-ийн нэн шаардлагатай тусламжийн багцыг оруулж яаралтай тусламжийн нөөцийг оновчтой тооцооллын дагуу бүрдүүлэх Гамшиг онцгой байдлын үеийн БНҮЭМ-ийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг Эх, хүүхэд, НҮЭМ-ийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөтэй уялдуулах, БНҮЭМ-ийн тусламж, үйлчилгээтэй холбоотой стандарт, журмуудад тусгаж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх Гамшиг, онцгой байдлын үед БНҮЭМ-ийн асуудлыг хэлэлцдэг үндэсний түвшинд зохицуулах ажлын хэсэг байгуулж, гамшгийн үеийн эрүүл мэндийн улсын албаны бүтцэд албан ёсоор оруулах.</p>		


158
2072

58

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. Ажилтай холбоотой сургалтуудад тухай бүр хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	1 сургалт	Богино хугацааны сургалтад хамрагдана	“Гамшгийн үед иргэдэд үзүүлэх БНҮЭМ-ийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт үндэсний сургагч багш бэлдэх сургалтад хамрагдсан. /2024.10.21-10.24 өдрүүд/	01-12 сар	100

59



2	Арга хэмжээ 2.2. Ажилтай холбоотой сургалтуудад тухай бүр хамрагдах	Мэргэжил аргазүйн удирдлагаар хангах	-	Заавар чиглэл өгнө	"Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулах Ажлын хэсгийг чөлөөтэй сургалтад хамрагдсан. / 2024.02 сард/	01-12 сар	100
---	--	---	---	-----------------------	---	-----------	-----

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

Халдварт бус өвчний хэлтсийн
дарга


..... / Г.Ганхуяг/

2024 оны 12 дугаар сарын 10

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын
газрын дарга


..... / Л.Баттөр/

2024 оны 12 дугаар сарын ...

